БАТЛАВ:
ДАРГА..... Б.ЭРДЭНЭЧИМЭГ

2021 оны 02-р сарын 11-ний өдөр

“ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Захиалагчийн нэр : Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГазар
Тендерийн нэр: “Хоол тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах”
Тендерийн дугаар: ХЭАБШСЗДТГ/202101001
Тендер явуулах журам: Харьцуулалт

Үнэлгээний ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:..... / Н.Маралгуа /

2021 он

БАТЛАВ:

ДАРГА..... Б.ЭРДЭНЭЧИМЭГ

2021 оны 02-р сарын 11-ний өдөр

“ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Захиалагчийн нэр : Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГазар
Тендерийн нэр: “Хоол тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах”
Тендерийн дугаар: ХЭАБШСЗДТГ/202101001
Тендер явуулах журам: Харьцуулалт

Үнэлгээний ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:..... / Н.Маралгуа /

2021 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2021.02.11

Тендер шалгаруулалтын нэр: Хоол тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар: ХЭАБШСЗДТГ/202101001

Эрх бүхий тендерт оролцогчдоос “Хоол тэжээлийн тусламж дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах” тендерт битүүмжилсэн үнийн саналыг цахимаар ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Төсөвт өртөг: 14 784 000 төгрөг

Тендерт оролцогч нь дараах санхүүгийн шаардлага хангасан байна.Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2020 оны борлуулалтын дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 30 хувиас багагүй.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2020 оны баталгаажуулсан А тайлан

Үнийн саналыг 2021 оны 02-р сарын 19-ний өдрийн 15^{00} цаг хүртэл цахимаар хүлээн авна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2021 оны 02-р сарын 19-ний өдрийн 15^{30} цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хэнтий аймаг Батширээт сумын ЗЗБУХТөслийн ажилтан Н.Маралгуа Утас:93223346

НЭГ. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	**1.1** Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 33 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2 . Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1 Тендерт оролцогч цахимаар тендерийн материалаа ирүүлнэ.
	2.2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл	3.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх бичиг баримт нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: **1.** Улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан байх / **2.** 2020 оны “А” санхүүгийн тайлан /жилийн эцсийн байдлаар/ **3.** 2019 оны борлуулалтын орлого нь Нийт төсөвт өртөгийн 50%-с багагүй байх. **4.** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ төсөвт өртгийн 30%-иас багагүй байх. **5.** Бусад нэмэлт шаардлага • ЗДТГазарт ажиллаж буй төрийн албан хаагчидтай хамаарал бүхий биш байх • Харъяалагдах татварын газрын тодорхойлолт • Харъяалагдах газрын нийгмийн даатгалын тодорхойлолт, НД-7, НД-8 маягтын дагуу 2020 оны сүүлийн 2 сарын тайлан • Харилцагч банкны тодорхойлолт • Дээрх тодорхойлолтуудтай холбоотой мэдээлэл авахад татгалзах зүйлгүй гэсэн албан тоот • Шинжилгээний бичиг /Мах, сүү, төмс хүнсний ногоо, өндөг /

	• Журамд заасан 10 нэр төрлийн бүтээгдэхүүнээс өөр нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх /хүүхдийн живх, ахуйн хэрэглээний бараа саван, шүдэнз, тор, давс, угаалгын нунтаг зэрэг/ баталгаа ирүүлэх, • Хүнсний эрхийн бичиг авдаг өрхөд бүтээгдэхүүнийхээ үнийг нэмж борлуулахгүй байх тухай баталгаа ирүүлэх • Иргэдтэй зүй бус харьцахгүй байх, жин дутуу болон хугацаа нь дууссан бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх баталгаа ирүүлэх • Иргэд үйлчилгээ авахдаа заагдсан бүтээгдэхүүнээс сонголт хийх боломжийг олгох /Сакура будаа, Өгөөж гурил бүтээгдэхүүн зэрэг/ • Импортын бараа бүтээгдэхүүн /лаазалсан бүтээгдэхүүн, хиам/ зэргийг олгохгүй байх • Хүнсний эрхийн бичгээр архи, согтууруулах ундаа, тамхи зэрэг хориглосон бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх. /Сүүлийн 6 шаардлагыг хангасан тухайгаа албан тоотоор ирүүлж болно./
4. Тогтмол үнэ	**4.**1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	5.1 Нийлүүлэх бараа нь энд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд үүнийг заавал мэдэгдэнэ.
	5.2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг батлах үүрэгтэй.

6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1 Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдыг харьцуулж шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана

ХОЁР. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	**Шалгуур үзүүлэлт**
ТОӨЗ 1.1	• Улсын бүртгэлийн гэрчилгээ / нотариатаар баталгаажуулсан байх/ • 2020 оны ”А”санхүүгийн тайлан Чадварын мэдээлэл: • Харъяалагдах татварын газрын тодорхойлолт • Харъяалагдах нийгмийн даатгалын газрын тодорхойлолт, НД-7, НД-8 маягтын дагуу 2020 оны сүүлийн 2 сарын тайлан • Харилцагч банкны тодорхойлолт • Дээрх тодорхойлолтуудтай холбоотой мэдээлэл авахад татгалзах зүйлгүй гэсэн албан тоот • Шинжилгээний бичиг / Мах, сүү, төмс хүнсний ногоо, өндөг/ • 2019 оны борлуулалтын орлого нь нийт төсөвт өртөгийн 50%-с багагүй байх. • Журамд заасан 10 нэр төрлийн бүтээгдэхүүнээс өөр нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх /хүүхдийн живх, ахуйн хэрэглээний бараа саван, шүдэнз, тор, давс, угаалгын нунтаг зэрэг/ баталгаа ирүүлэх, • Хүнсний эрхийн бичиг авдаг өрхөд бүтээгдэхүүнийхээ үнийг нэмж борлуулахгүй байх тухай баталгаа ирүүлэх • Иргэдтэй зүй бус харьцахгүй байх, жин дутуу болон хугацаа нь дууссан бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх баталгаа ирүүлэх • Иргэд үйлчилгээ авахдаа заагдсан бүтээгдэхүүнээс сонголт хийх боломжийг олгох /Сакура будаа, Өгөөж гурил бүтээгдэхүүн зэрэг/ • Импортын бараа бүтээгдэхүүн /лаазалсан бүтээгдэхүүн, хиам/ зэргийг олгохгүй байх • Хүнсний эрхийн бичгээр архи, согтууруулах ундаа, тамхи зэрэг хориглосон бүтээгдэхүүнээр үйлчлэхгүй байх. • И баримт хэвлэж иргэдэд өгдөг байх энэ тухайгаа баталгаажуулж ирүүлэх /Сүүлийн 7 хоногт хэвлэсэн и баримтыг хуулбарлаж ирүүлэх

	/Сүүлийн 7 шаардлагыг хангасан тухайгаа албан тоотоор ирүүлж болно./
ТОӨЗ 2,1	**Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа:** **Байгууллагын хаяг:** Батширээт сумын ЗДТГ **Огноо:** 2021 оны 02-р сарын 19-ний өдөр **Цаг:**15^{00} цаг
ТОӨЗ 2,1	**Тендерийн нээлт хийх газар:** Хэнтий аймгийн Батширээт сумын ЗДТГ-ын 2-р давхар 3 тоот өрөө Засаг даргын орлогчийн өрөө **Тендерийн нээлт хийх хугацаа:** 2020 оны 02-р сарын 19 **Цаг**: 15^{30} цаг
ТОӨЗ 3,2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр бүхий 10 бүтээгдэхүүнээс бүрдэнэ. 1. Мах, махан бүтээгдэхүүн 2. Сүү, сүүн бүтээгдэхүүн 3. Гурил, гурилан бүтээгдэхүүн 4. Цөцгийн тос 5. Элсэн чихэр 6. Төмс, хүнсний ногоо 7. Будаа 8. Ургамлын тос 9. Өндөг 10. Жимс, жимсгэнэ

ГУРАВ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт, Стандарт

Нэр төрлийн дугаар	**Бараа болон холбогдох үйлчилгээний нэр**	**Техникийн тодорхойлолт болон стандарт**
1.	Мах, махан бүтээгдэхүүн	**Ерөнхий зүйл:** Нийлүүлэгдэх мах нь стандартын шаардлага хангасан байна. - Мах нь шинэ чийгээ алдаагүй, технологийн дагуу цэвэрлэж, хөлдөөсөн, гадаргуу цэвэр, гадны үнэр, амт байхгүй байна.(шивтэр, бензин гэх мэт хэвлийн хөндийд дайвар бүтээгдэхүүн болон махны ялгадасгүй байх) - Лабораторийн шинжилгээний бичиг болон гарал үүслийн бичигтэй байна. - Шаардлагатай тохиолдолд захиалагч байгууллага шинжилгээнд давтан оруулсан тохиолдолд шинжилгээний төлбөрийг нийлүүлэгч тал хариуцах (төлбөр төлөх) - Хонь, ямаа, үхрийн мах гэж үнийн саналыг бичнэ.
2.	Сүү, сүүн бүтээгдэхүүн	**Ерөнхий зүйл**: Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь стандартын шаардлага хангасан байна. - Зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. - Лабораторийн шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй байна. - Нийлүүлэгдэх сүү, сүүн бүтээгдэхүүн нь эх орны бүтээгдэхүүн байна. **Барааны нэр: Шингэн сүү** - Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна. - Гадны үнэр, амт байхгүй, тослог зохих түвшинд

		байх, шинэ, шингэн болон хөлдөөсөн байна. - Тээвэрлэлтийн горимыг баримтлана. **Барааны нэр: Аарц:** - Монгол аргаар бэлтгэгдсэн, стандартын шаардлага хангасан байна./Хог хаягдал шавьж хорхойгүй./ - Цагаан өнгөтөй - Хэт исгэлэн гашуун, хахарсан, хөгцөрсөн биш байна. - Нэрмэлийн биш байх. **Барааны нэр: Тараг:** - Монгол аргаар бэлтгэсэн байна. - Стандартын шаардлага хангасан байна. - Шинэ байна. - Исээгүй, нэгэн жигд бие бүтэцтэй, шингэн биш байх. - Задгай тараг нь эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.
3.	Төмс, хүнсний ногоо	**Ерөнхий зүйл:** Нийлүүлэгдэх ногоо нь орон нутагт тариалагдсан, стандартын шаардлага хангасан байна. - Хорхой идэгдээгүй байх. **Барааны нэр: Төмс** - Гэмтэж муудаагүй, зөөлрөөгүй, соёолоогүй, хайрагдаагүй, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. /Гадаргууд нь шороо чулуу наалдаагүй байх/ - Стандартын шаардлага хангасан үрээр тарьсан байх. **Барааны нэр: Байцаа** - Байцаа нь нягтрал сайтай, муудаж гэмтээгүй гадны үнэр амтгүй, ялзраагүй байх.

		- Байцааны дундаж жин нь 2-2,5 кг байх **Барааны нэр: Бөөрөнхий сонгино** - Ялзарч муудаагүй, хатаж чийгээ алдаагүй, ааг амт сайтай, гадны үнэр амтгүй, элдэв механик хольцгүй байна. - Соёолж хөгшрөөгүй байхаас гадна 1ш сонгины дундаж жин 100-150 гр байх **Барааны нэр: Лууван** - 1 ш луувангийн дундаж жин нь 200-300 гр байх ба механик элдэв хольцгүй, зөөлөрч муудаагүй, чийгээ алдаагүй, соёолоогүй, гадны үнэр амтгүй байна. - Лууванд агуулагдах коратин болон бусад төрлийн амин дэм нь алдагдаагүй, багавтар чихэрлэг амттай улбар шар өнгөтэй байна. **Барааны нэр: Манжин** - Шар, хүрэн манжин нь стандартын шаардлага хангасан байна. - Гэмтээгүй, ялзарч муудаагүй, хөгшрөөгүй шинэ байна. - Гадаргууны үндэс навч, шороог бүрэн цэвэрлэсэн байх. **Барааны нэр: Нарийн ногоо** - Хэт хөгшрөөгүй чийгээ алдаагүй, хөгц үүсч муудаагүй, шинэ байна. - Өргөст хэмх нь цайвар ногоон өнгөтэй гашуун биш байна. - Дундаж жин нь 250-280гр, 4-5 см диаметртэй байна. - Улаан лооль нь бяцарч гэмтээгүй, хэт исгэлэн гашуун биш, болц гүйцсэн байна.
4.	Будаа	**Ерөнхий зүйл**: - Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн

		бүтээгдэхүүн байна. - Зориулалтын сав, баглаанд савласан байна. - Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байна. **Барааны нэр: будааны төрөл(цагаан, хөц, гурвалжин, шар, хүүхдийн будаа)** - MNS 0142:1985 техникийн шаардлага хангасан байна. - Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, бутарч хуваагдаагүй байна. - Цагаан будаа нь том ширхэгтэй, агшаахад нялцайхгүй байх
5.	Элсэн чихэр	**Ерөнхий зүйл**: - Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. - Зориулалтын сав, баглаанд савласан байна. - Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх **Барааны нэр: Элсэн чихэр** - MNS 0244:1999 техникийн шаардлага хангасан байна. - Гадны үнэр амтгүй, механик хольцгүй байна
6.	Гурил, гурилан бүтээгдэхүүн	**Ерөнхий зүйл**: - Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. - Зориулалтын сав, баглаанд савласан байна. - Хадгалалтын хугацаа дуусаагүй бүтээгдэхүүн байх **Барааны нэр: гурил, гурилан бүтээгдэхүүн** - MNS 0244:2009 техникийн шаардлага хангасан байна. - Гадны механик хольцгүй ба үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй байна.

		- Чийгээ алдаагүй шинэ байна.
7.	Ургамлын тос	**Барааны нэр: Ургамлын тос** - Стандартын шаардлага хангасан байна. - Зориулалтын сав баглаанд савласан байна. - Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (элдэв өнгө, амт үнэргүй байна)
8.	Цөцгийн тос	**Барааны нэр: цөцгийн тос** - Стандартын шаардлага хангасан үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. - Тослогийн хэмжээ 82%-аас багагүй байна. - Эрүүл ахуйн шаардлага хангасан байна.(хайлаагүй, хөгцгүй, элдэв амт үнэргүй байна.)
9.	Жимс, жимсгэнэ	**Барааны нэр: жимс жимсгэнэ** - Стандартын шаардлага хангасан байна. - Зориулалтын сав баглаанд савласан байна. - Эрүүл ахуйн шаардлага хангасан байна. (элдэв өнгө, амт үнэргүй, хатаж хорчийгоогүй, хөгцгүй, шороо чулуугүй, хог хаягдалгүй байна.) - Шинэ жимс нь исээгүй, няцраагүй, хорхой идээгүй, хөгцрөөгүй, иш, навчгүй байна.
10.	Өндөг	**Барааны нэр: өндөг** - Стандартын шаардлага хангасан байна. - Зориулалтын сав баглаанд савласан байна. - Эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

1. Баглаа, боодол:

- Махыг тээвэрлэх, хадгалах явцад гадны нөлөөллөөс хамгаалан гадуур нь гялгар уутаар ороосон байх,
- Хүнсний ногоо тус тусдаа савлагдсан, гадны шороо чулууны хольцгүй байх,
- Сүүн бүтээгдэхүүнийг зориулалтын таглаатай ариутгасан саванд савлаж тээвэрлэх ба гашилж муудахаас хамгаалах,
- Гурилыг зориулалтын машинаар тээвэрлэх,

- Кг-ын болон хуурай хүнс, тос, будааг тус бүр зориулалтын саванд савласан байх ба гадны тоос шороо орохоос сэргийлсэн, хадгалах хугацаа нь тодорхой заагдсан, тээвэрлэлтийн явцад гэмтэж муудах, хагарч асгарахаас хамгаалагдсан байна.

2.Барааг иргэд өөрийн биеэр очиж сонгогдсон дэлгүүрээс авна.

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорх ойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:
Санал болгож буй бусад нөхцөл:
Тендерт оролцогчийн нэр:
Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:
Албан тушаал, нэр:
Хаяг

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Тухайн сард нийлүүлэх барааг бүрэн нийлүүлсэн тохиолдолд бараа хүлээн авсан падан, нэхэмжлэл болон е-баримт олгосон тухайн сарын тайлан бүрэн гүйцэд хийсэн тохиолдолд сар бүрийн 25-наас хэтрэхгүй ажлын 5 хоногт төлбөрийг 100 хувь олгоно.
8. Бараа нийлүүлэх	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод

хуваарь		заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. **Маргааныг шийдвэрлэх**	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)	1.1	Захиалагч, эсхүл түүний төлөөлөгч хүнсний цахим талон хэвлэх явцад хэвлэсэн эх загварыг нийлүүлэгчийн ажлын байран дээр очиж шалгаж үзнэ.
2. Барааны нийлүүлэлт баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)	2.1	Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг олгосон тухай баримт, 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ, 4) барааны гарал үүслийн гэрчилгээ. Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН–5)

Баталгаат засварын тусгай шаардлага Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүнсний цахим талоныг нийлүүлээгүй тохиолдолд үүсэх хохирлыг нийлүүлэгч ажлын 3 хоногийн дотор өөрийн зардлаар барагдуулна.

4. Төлбөр (ГЕН – 7)

Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

1. Хүнсний цаасан талоныг хэвлэн, орон нутаг дахь салбараар дамжуулан хөтөлбөрт хамрагдсан өрхөд нэг удаа олгоно.

2. Хүнсний талоныг алдсан, гээсэн зэрэг тохиолдолд дахин хэвлүүлэх төлбөрийг хүнсний талон эзэмшигч хариуцна.

3. Хөтөлбөрт хамрагдсан өрхийн хүнсний цахим талоноор бүтээгдэхүүн худалдан авах санхүүжилтийг ХХН-ээс сар бүр шилжүүлнэ.

4. Хөтөлбөрт хамрагдсан өрх хүнсний цахим талоноор тухайн нутаг дэвсгэрт үйлчлэхээр сонгон шалгарсан дэлгүүрийн карт уншигч машинд цахим талоныг уншуулах бөгөөд банк нь уг өрхийн худалдан авсан хүнсний бүтээгдэхүүний төлбөрийг дэлгүүрийн дансанд тухай бүр шилжүүлнэ.

7.1. Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.